



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 02 сарын 16 өдөр

Дугаар А/11

Улаанбаатар хот

Сар шинийн баярын өдрүүдэд  
хариуцлагатай эргүүл томилон  
ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.1.2 дахь заалт, “Нийслэлийн Өмчийн харилцааны газрын дүрэм”-ийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Цагаан сар”-ын нийтээр тэмдэглэх баярын өдрүүдэд буюу 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн 2023 оны 02 дугаар сарын 23-ны өдрийг дуустал ажиллах хариуцлагатай эргүүлийн нэрсийг хавсралтаар баталсугай.

2.Хариуцлагатай эргүүл дараах чиглэлээр ажиллахыг даалгасугай.

2.1.Хариуцлагатай эргүүл нь “Улаанбаатар хотын Шуурхай удирдлага, зохицуулалтын төв” ОНӨТҮГ-тай холбоотой ажиллаж, мэдээг 310005, 75771005 дугаар утсанд өгөх;

2.2.Хариуцлагатай эргүүлээр ажиллаж байх хугацаанд шуурхай мэдээ, мэдээллийг нэг бүрчлэн хүлээн авч (утасны дугаар, цаг хугацаа, мэдээлсэн эзэн) бүртгэн, холбогдох нэгжийн даргад шуурхай мэдээлэн, авсан арга хэмжээний талаар бүртгэлийн дэвтэрт тэмдэглэх;

2.3.Хариуцлагатай эргүүл нь байгалийн гамшиг, гэнэтийн осол болон хэвийн үйл ажиллагаанд нөлөөлөх асуудал гарвал нэгжийн дарга, газрын даргад шуурхай мэдээлж, удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу арга хэмжээг шуурхай авч ажиллах;

2.4.Хариуцлагатай эргүүл нь өрөөний лац, цахилгаан, сантехникийн системийн хэвийн ажиллагаа, гал унтраах хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг шалгаж, үүрэг гүйцэтгэсэн байдлын талаар тэмдэглэл хөтлөн дараагийн ээлжийн эргүүлд үлдээх;

3.Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа хариуцсан ажилтан 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн ажлын цаг дуусахад албан хаагчдад цахилгаан хэрэгслээ салгах, аюулгүй байдал хангах талаар мэдээлэл өгч ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт дотоод аудитын хэлтсийн мэргэжилтэн (С.Сэржжаргал)-д даалгасугай.

4.Хариуцлагатай эргүүлээр ажилласан албан хаагчдыг нөхөн амруулах, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, тухайн хугацаанд ажилласан тайланг илтгэх хуудсаар танилцуулж ажиллахыг Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн дарга (М.Мөнхбаяр)-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ч.САЙХАНБАЯР

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын  
даргын 2023 оны ~~02~~ дугаар сарын ~~16~~-ны  
өдрийн ~~11~~ тушаалын хавсралт

Хариуцлагатай эргүүл томилон  
ажлуулах тухай

№	Хариуцлагатай эргүүлийн нэрс	Албан тушаал	Эхлэх		Дуусах		Гарын үсэг
			Өдөр	Цаг	Өдөр	Цаг	
1.	Н.Энхмөнх	ӨХАДАХ-ийн Ахлах мэргэжилтэн	02.20	14:00	02.20	20:00	
2.	П.Түвшинжаргал	ЗТСХ-ийн мэргэжилтэн	02.21	08:00	02.21	14:00	
3.	Ш.Дарьсүрэн	ӨХАДАХ-ийн мэргэжилтэн	02.21	14:00	02.21	20:00	
4.	Б.Эрдэнэмөнх	ӨБМХ-ийн мэргэжилтэн	02.22	08:00	02.22	14:00	
5.	Н.Уранчимэг	ӨБМХ-ийн мэргэжилтэн	02.22	14:00	02.22	20:00	
6.	Х.Баттуяа	ӨМХ-ийн мэргэжилтэн	02.23	08:00	02.23	14:00	
7.	Б.Батаа	ӨМХ-ийн мэргэжилтэн	02.23	14:00	02.23	20:00	